

ГАРЧИГ

<i>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	3
1.1. <i>Төслийн ерөнхий мэдээлэл</i>	3
1.2. <i>Уурхайн хүчин чадал, уулын ажлын төлөвлөлт, горим</i>	5
1.3. <i>Ашиглалтын систем, тоног төхөөрөмжийн сонголт</i>	9
1.4. <i>Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц</i>	9
1.5. <i>Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө</i>	12
<i>ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	13
<i>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ</i>	18
3.1. <i>Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим</i>	18
<i>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</i>	22
4.1. <i>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</i>	23
4.2. <i>Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө</i>	28
4.3. <i>Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө</i>	28
4.4. <i>Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө</i>	29
4.5. <i>Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө</i>	29
4.6. <i>Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд</i>	29
4.7. <i>Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө</i>	30
4.8. <i>Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал</i>	31
4.9. <i>Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр</i>	33
4.10. <i>Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө</i>	35
4.11. <i>Төслийн нөлөөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь</i>	35

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн солбилцол.....	4
Хүснэгт 2. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө.....	5
Хүснэгт 3. Уурхайд ашиглагдах тоног төхөөрөмжийн жагсаалт	9
Хүснэгт 4. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	18
Хүснэгт 5. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах	Error! Bookmark not defined.
Хүснэгт 6. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл.....	Error! Bookmark not defined.
Хүснэгт 7. Гол сөрөг нөлөөлөл.....	20
Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал.....	23
Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	28
Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	28
Хүснэгт 11. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	29
Хүснэгт 12. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	29
Хүснэгт 13. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	30
Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	31
Хүснэгт 15. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө....	Error! Bookmark not defined.
Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	33
Хүснэгт 17. Олон нийтийн оролцоог хангах арга хэмжээний төлөвлөгөө	35
Хүснэгт 18. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын тооцоо.....	36

ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн топо зураг 1:50000.....	4
---	---

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: “Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийн чулуун нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах” төсөл

Төсөл хэрэгжүүлэгч: “Пауэрлэнд” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011247064, Регистрийн дугаар: 2843129, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл: MV-021718

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн мэдээлэл: **тусгай тухай** Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газраас Ашигт малтмалын тухай Монгол улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Арын худаг нэртэй газар орших 132.88 га талбай бүхий ашигт малтмалын MV-021717 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл, мөн Алагтолгой нэртэй газар орших 1,278.63 га талбай бүхий ашигт малтмалын MV-021718 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдөр “Пауэрлэнд” ХХК-д олгосон байна.


Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 19-р хороо, 4-р хороолол, 54-13 тоот. Утас: 9911-7481

Төслийн байршил: “ПАУЭРЛЭНД” ХХК-ийн эзэмшдэг Алагтолгойн чулуу, арын худаг нэртэй нүүрсний орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 270 км, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын төвөөс баруун хойш 28 км, УБ- Сайншанд төмөр замын 25-р зөрлөгөөс 24 км зайд оршино.

Талбайн солбицлын цэгүүд:

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн солбилцол

Д/д	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбайн хэмжээ, га	Өргөрөг			Уртраг		
			Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	MV-021718	1278.63	46	11	01.64	109	02	10.7
2			46	10	16.64	109	02	10.7
3			46	10	16.66	109	03	01.71
4			46	08	01.65	109	03	01.71
5			46	08	01.65	109	01	01.71
6			46	11	01.64	109	01	01.71
1	MV-021717	132.88	46	3	1.71	109	11	1.64
2			46	2	10.7	109	11	1.64
3			46	2	10.7	109	10	43.65
4			46	2	28.71	109	10	43.65
5			46	2	28.71	109	10	27.66
6			46	2	10.7	109	10	27.66
7			46	2	10.7	109	10	10.64
8			46	3	1.71	109	10	16.65



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн топо зураг 1:50000

1.2. Уурхайн хүчин чадал, уулын ажлын төлөвлөлт, горим

1.2.1. Ил уурхайн одоогийн төлөв байдал

“Пауэрлэнд” ХХК нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Элдэв багийн нутагт ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн MV-021718, MV-021717 тоот дугаартай талбайд “Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг ил аргаар ашиглах” төслийг (цаашид Алагтолгойн уурхай гэх) хэрэгжүүлдэг.

MV-021718 тоот тусгай зөвшөөрөлт Алагтолгой, MV-201717 тоот тусгай зөвшөөрөлт Арын худаг нэртэй газрын Алагтогоогийн нүүрсний ордуудад 2010-2011 онуудад хийгдсэн хайгуулын ажлын үр дүнд ордын нөөцийг тогтоосныг Ашигт малтмалын газрын даргын 2012 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 93 тоот тушаалаар улсын нэгдсэн бүртгэлд бүртгэн, уг ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийн тодотгол-2-ыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2024 оны 02 дүгээр сарын 08- ны өдрийн Т/07 тоот тушаалаар батлаж хүлээн авсан. “Алагтолгойн уурхай”-г ил аргаар олборлож ашиглахаар төслийн ТЭЗҮ-д тусгагдсан байна.

“Пауэрлэнд” ХХК нь тус ордод 2014 болон 2019 онуудад олборлолтын үйл ажиллагаа явуулсан бөгөөд энэ хугацаанд 2-В, 4-В, 14-С, 23-С блокод үйл ажиллагаа явуулж бодитой В+С зэрэглэлээр 208.57 мян.тн нүүрс олборлож, 2,436.2 мян.м³ хөрс хуулсан байна. Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийн геологийн үлдэгдэл нөөцийн хэмжээг 2022 оны уулын ажлын тайлан болон маркшейдерийн хэмжилтэнд тулгуурлан тогтооход Алагтолгойн хэсэгт нийт В+С зэрэглэлээр 1,165.54 мян.тн нүүрсний үлдэгдэл нөөцтэй гэж ТЭЗҮ тодотгол-2-т тусгагдсан байна.

1.2.2. Уурхайн жилийн хүчин чадал

Уурхайн жилийн хүчин чадлыг жилд 100 мян.тн нүүрс олборлож 10 жилийн хугацаагаар төлөвлөгөөнд тусгалаа. Алагтолгойн ордын ашиглалтын нийт хугацаанд 1014.1 мян.тн нүүрс олборлож 6045 сая.м³ хөрс хуулалтын ажил хийнэ.

Хүснэгт 2. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Ашиглалтын жил	В нөөц, мян.тн	С нөөц, мян.тн	Нүүрс олборлолт В+С, мян.тн	Хөрс хуулалт, мян.м ³			Уулын цул, мян.м ³	Хөрс хуулалтын харьцаа м ³ /тн
				Шимт хөрс	Гадаад овоолго	Дотоод овоолго		
1 дэх жил	40	60	100	5	639	-	744	6.44
2 дахь жил	39	61	100	5	644	-	749	6.49
3 дахь жил	37	63	100	5	642	-	747	6.47
4 дэх жил	37	63	100	5	640	-	745	6.45
5 дахь жил	37	63	100	5	641	-	746	6.46
6-10 дахь жил	185.4	328.69	514.1	24.11	678.14	2,516.49	3,732.84	6.26

Нийт	375.4	638.69	1,014.10	49.11	3,884.14	2,516.49	7,463.84	6.36
------	-------	--------	----------	-------	----------	----------	----------	------

1.2.3. Уурхайн ажиллах горим

Тус уурхай нь жилийн баяр ёслол, амралтын өдрүүдээс бусад бүх өдрүүдэд хөдөлмөрийн хуулийн дагуу ажиллана.


Жилд ажиллах хоногийн тоо:

- ✓ Жилийн нийт хоног – 365
- ✓ Жилд ажиллах хоног – 312
- ✓ Амралт, баяр ёслолын хоног – 17
- ✓ Урсгал засвар хийх өдрүүд – 36
- ✓ Ээлжийн тоо – 2 ээлж
- ✓ Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа – 12 цаг

1.2.4. Уурхайн талбайг ашиглах дараалал

Ил уурхайн үйл ажиллагааны дараалал:

1. Хөрс хуулалт,
 - 1.1. Шимт хөрс түрж хуулах
 - 1.2. Шимт хөрс ачих
 - 1.3. Шимт хөрс тээвэрлэх
 - 1.4. Өрөмдлөг тэсэлгээ
 - 1.5. Хөрс ухаж ачих
 - 1.6. Хөрс тээвэрлэх
 - 1.7. Гадаад дотоод овоолгод хураах
 - 1.8. Овоолго түрэх
2. Нүүрс олборлолт,
 - 2.1. Нүүрс Ухаж ачих
 - 2.2. Тээвэрлэх
 - 2.3. Овоолох (Түр овоолгод хураах)



Зураг 2. Технологийн бүдүүвч зураг

Шимт хөрс хуулах, ачих, тээвэрлэх: Шимт хөрсийг SHANTUI SD42-3 маркийн бульдозероор түрж хуулан утгуурт ачигчаар автосамосвалд ачин тээвэрлэж шимт хөрсний овоолго руу тээвэрлэнэ. Шимт хөрсний овоолгыг 2-3 метрийн өндөртэй 35°-38° налуутайгаар үерийн ус болон салхины нөлөө бага байх газар байгуулна. Шимт хөрсийг уурхай, овоолгын суурийн талбайгаас 0.3 м-ийн зузаантайгаар хуулна. Ил уурхайгаас 49.11 мян.м3, овоолгын суурийн талбайгаас 22.88 мян.м3 шимт хөрс, нийт 71.99 мян.м3 шимт хөрс хуулна.

Өрөмдлөг: Чулуулгийн бат бөхийн тооцооноос харахад өрөмдлөг тэсэлгээ хийх шаардлагатай.

Эргэлтэт өрөмдлөгийн арга тохиромжтой. Ажиллах экскаваторын утгуурын багтаамжаас цооногийн диаметрыг тооцоход 110 мм-ийн диаметртэй өрмийн хошуу бүхий эргэлтэт өрмийн машин хамгийн оновчтой ба компанийн өөрийн эзэмшлийн ECD45E маркийн өрмийн машинаар өрөмдөх боломжтой гэжээ.

Тэсэлгээ: Орд нь гидрогеологийн хувьд шүүрлийн устай учир “ANFO” тэсрэх бодис болон “Эмульсийн” тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан хэрэглэнэ. Тэсэлгээг 7 хоногт 1 удаа тогтсон өдөр явуулах бөгөөд Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу аюулгүй байдлыг дээд зэргээр хангасны үндсэн дээр тэсэлгээг хийнэ. Нэг удаагийн тэсэлгээнд дунджаар 66 ширхэг цооногт 2.44 тн тэсрэх бодис хэрэглэнэ. Хөрсний чулуулгийн бутлалын чанарыг сайжруулах, чулуулгийн шидэгдэл, хөрсний тархалтыг багасгах, тэсэлгээний улмаас гарах аюул, ослыг багасгах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахын тулд тэсэлгээнд 0.20 м/сек хурдтай түр удаашруулагчийг хэрэглэнэ. Тэсэлгээний ажлыг ээлжийн төгсгөлд гүйцэтгэнэ. Төсөл хэрэгжих явцад нийт 327.0 тн анфо тэсрэх бодис, 763.3 тн эмульсийн тэсрэх бодис түүнд хамаарах тэсэлгээний хэрэгсэлийн хамт хэрэглэхээр байна.

Тэсэлгээний ажлыг мэргэжлийн оператор компанитай гэрээлэн гүйцэтгүүлнэ.

Ухааж ачих: Ил уурхайн нүүрс олборлолт DAEWOO DH420LC-7 маркийн 2.1 м3-ийн утгуурын багтаамжтай экскаватор ажиллана. Хөрс хуулалтын ажилд DOOSAN DH500LC-7 маркийн 3.2 м3-ийн утгуурын багтаамжтай экскаватор ашиглана.

Уурхайн дотоод тээвэр: Уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтонд ашиглах автосамосвал нь тухайн мөргөцгөөс тээвэрлэж хөрсийг хөрсний гадаад, дотоод овоолго, нүүрсийг түр овоолго хүртэл тээвэрлэн хураана. Уурхайн гүнзгийрэлт болон овоолгын ахилтаас хамаарч дотоод тээврийн автосамосвалуудын тээврийн зай харилцан адилгүй

байна. Мөн олборлолтоос өмнө шимт хөрс тээвэрлэнэ. Дотоод тээвэрт БНХАУ-д үйлдвэрлэсэн Howo маркийн 25 тн даацтай автосамосвал ашиглана. Алагтолгойн нүүрсний ил уурхайд хөрс тээвэрлэхэд 2 ш, нүүрс тээвэрлэхэд 1 ш, шимт хөрс тээвэрлэхэд 1 ш, нийт 4 ширхэг автосамосвал ашиглана.

Хөрсний овоолго: Төсөл хэрэгжих хугацаанд нийт 6.46 сая.м3 хөрс хуулах ба сийрэгжилт тооцсоноор 8.3 сая.м3 хөрс байна. Үүнээс эхний 6 жилд гадаад овоолгод 5.0 сая.м3 хөрс, 6 дахь жилийн дунд үеэс эхлэн 3.3 сая.м3 хөрс дотоод овоолгод хураана. Овоолго дээр Shantui SD42-3 маркийн өндөр хүчин чадалтай бульдозер ашиглана. Овоолгын процесс нь автосамосвалоор хөрсийг буулгаж үлдэц асгацыг бульдозероор түрэн захлах хэлбэрээр овоолго байгуулна. Овоолго байрших талбайн шимт хөрсийг хуулах, овоолгын суурь үерийн болон борооны усанд элэгдэж нуралт үүсэхээс сэргийлэн далан шуудуу татах гэсэн ажлуудыг овоолго байгуулахаас өмнө нь хийнэ.

Нүүрсний ачилт: Нүүрсний түр овоолгын талбайд LIUGONG 855N маркийн 3.0 м3 утгуурын багтаамжтай утгуурт ачигчаар гадаад тээврийн автосамосвалд нүүрс ачна. Уурхайн олборлолт эхлэхээс өмнө шимт хөрс ачсаны дараа нүүрсний түр овоолгын байгуулна.

Уурхайн доторх болон гадаргуугийн зам: Ил уурхайн доторх тээврийн автозамыг байнга хянах ба засч тэгшлэх, тоос дарах зэрэг ажлууд хийгдэнэ. Зам услагч машин тодорхой чиглэлийн дагуу явж замын тоос дарж ус шүршинэ. Шаардлагатай тохиолдолд замд хэсэгчлэн тоос дарах ажиллагааг хэрэгжүүлнэ. Хэрэв цаг агаар, хөдөлгөөний эрчмийн байдлаас шалтгаалан тоосжилт ихэсвэл замын тоос дарах ажиллагааг давтан явуулна. Замын засвар үйлчилгээний ажлыг үйл ажиллагааны явцад байнга хийж гүйцэтгэнэ. Замын засвар үйлчилгээний ажилд Shantui SD42-3 маркийн бульдозер, утгуурт ачигч ашиглах ба шаардлагатай тохиолдолд уурхайгаас нэмэлт тоног төхөөрөмж татан ажиллуулна.

1.3. Ашиглалтын систем, тоног төхөөрөмжийн сонголт

1.3.1. Уулын үндсэн ажилд хэрэглэгдэх тоног төхөөрөмжүүд

Уурхайд хэрэглэх тоног төхөөрөмж, техникийг сонгохдоо тус ордыг ашиглах өмнөх ТЭЗҮ-г үндэслэн тус төсөлд сонгосон техникүүдийг ашиглахаар тооцлоо. Үүнд: Уурхай дээр хөрс хуулалт, олборлолтонд 1.3 м³ багтаамжтай шанага бүхий урвуу утгууртай Хьюндай (Hyundai R210LC-7) маркийн экскаватор, хөрс болон нүүрс тээвэрлэлтэнд Хятад улсад үйлдвэрлэдэг 25 тн-ын даацтай Хово (Howo) маркийн автосамосвал, нүүрсний гадаад тээвэрт дунджаар 24 км тээвэрлэхэд 40 тн-ын даацтай мөн Хятад улсад үйлдвэрлэдэг Хово (Howo) маркийн автосамосвал, өрөмдлөгийн ажилд KQG-120Y маркийн өрмийн машин, овоолгын хөрс түрэлтэнд Хятад улсад үйлдвэрлэсэн Эс Ди (SD-23) маркийн бульдозер, уурхайн нөхөн сэргээлт, зам засварлах зэрэг туслах ажлуудад Хятад улсад үйлдвэрлэдэг PУ-200 маркийн грейдерийг ашиглахаар ТЭЗҮ-н тодотгол тооцоонд тусгасан болно. Уурхайд ажиллах тоног төхөөрөмжийг хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3. Уурхайд ашиглагдах тоног төхөөрөмжийн жагсаалт

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Шаардлагатай тоо
Ил уурхай			
1	Экскаватор	Hyundai R210LC-7	3
2	Авто самосвал /хөрс/	HOWO	4
3	Авто самосвал /нүүрс/	HOWO	1
4	Авто самосвал /гадаад тээвэр/	HOWO	4
5	Өрмийн машин	KQG-120Y	1
6	Бульдозер	Shantui SD23	1
7	Утгуурт ачигч	ZL-50	1
8	Авто грейдер	PУ-200	1
9	Зам усалгааны машин	-	2

1.4. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц

Хүснэгт 4. Уурхайн барилга байгуулам жууд

№	Барилгын нэр	Хэмжих нэгж	Хэмжээ, м ²
1	Уурхайн удирдлагын байр	Сэндвич	950.0
2	Ажилчдын сууц 1 дор 60 хүн байрлах	Сэндвич	1500.0
3	Цайны газар 1 дор 60 хүн хооллох	Сэндвич	400.0
4	Халуун ус болон угаалга 10 хүний х/ч	Сэндвич	220.0
5	Гараж	Сэндвич	400.0
6	Харуулын байр	Сэндвич	18.0
7	ТБ-ын агуулах 60 тн х/ч	Блокон	250.0
8	Хамгаалалтын хашаа	Блокон	250.0
9	Засварын газар	Блокон	2500.0
10	Сэлбэгийн агуулах	Блокон	300.0
11	Шатахуун түгээх газар	Блокон	250.0
12	Уурын зуух	Блокон	200.0

Ажилчдын барилга байгууламж

Ил уурхайд жилд дунджаар 91 хүн ажиллах юм. ажилчид нь уурхай дээр 14 хоног ажиллаад 14 хоног амрахаар 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Ажилчдын хотхон нөөц тооцсоноор 60 хүн зэрэг байрлах хүчин чадалтай байна. Уурхайн удирдлагын байр, ажилчдын амрах байр, цайны газар, ажилчдын халуун ус, харуулын байр, сэлбэг материалын агуулах зэргийг сендвичээр барьж байгуулсан байна. Харин тэсрэх бодисын агуулах, засварын газар, уурын зуух зэргийг блокоор барьж байгуулна.



Зураг 3. Уурхайн кемп

Шатах тослох материалын агуулах.

Уурхайн түлшний сарын хэрэглээ 35 мян.л бөгөөд түлшний агуулах нь 60 мян.л түлш хадгалах багтаамжтай байна. Энэ нь тусдаа шахуурга болон шүүлтүүртэй. Түлшийг шүүж цэвэрлэсний дараа тоног төхөөрөмжүүдийг түлшээр цэнэглэнэ. Мөн түлш ачих, буулгах хэсэгт гал унтраах, аянга зайлуулагч хэрэгслүүд байрлана. Түлш асгарч хөрсийг бохирдуулахаас сэргийлж автомашин цэнэглэх талбайг хатуу хучилттайгаар хийж өгнө.

Тэсрэх бодисын агуулах:

Тэсрэх бодис болон тэсэлгээний материалын агуулахыг ил уурхайн тэсэлгээний аюултай бүсээс гадагш байгуулна. Блокон хийцлэлээр 1ш тасалгаа бүхий барилга, зөөврийн контейнерээр тус тус 20 тн багтаамж бүхий 2 ш байгууламж байна.

Цахилгаан хангамж

Уурхайн цахилгааны гол хэрэглэгчид нь өрмийн машин, ил уурхайн цахилгаан гэрэлтүүлэг болон ажилчдын хотхон, засвар механикийн цех, уурхайн захиргаа зэрэг хэрэглэгчид байх юм. Тус уурхай нь Элдэвийн нүүрсний уурхайтай зэргэлдээ орших учир уурхайн хэрэглэгчдийг Элдэвийн уурхайн хэрэглэгчид тэжээгдэж байгаа Даланжаргалан сумын төвөөс татагдсан 10 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан

дамжуулах шугамнаас салбарлуулан 6/0.4кВ-ын бууруулах трансформаторын дэд станцаар дамжуулан уурхайн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангахаар тусгав. Цахилгаан хангамжийн эх үүсвэрт АС-25 маркийн утастай 10 кВ-ын агаарын шугам, КТП-250 төрлийн 10/0.4 кВ-ын трансформаторын иж бүрэн дэд станц, 0.4 кВ-ын кабель болон агаарын шугамыг ашиглах бөгөөд нийт 117.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэнэ.

Ус хангамж

Ундны усны хэрэглээнд жилд нийт 1460.0 тн ус хэрэглэнэ. Уурхайн унд ахуйн усны хэрэглээг худгийн уснаас хангана. Худаг нь анх 2018 онд өрөмдөн гаргасан 97 м-ийн гүнтэй, 10 м-ийн статиктай, 2л/с ундарга бүхий өрөмдмөл худаг юм. Худгийн байршлын солбилцол нь З.У 109° 01' 0.75", Х.Ө 46° 10' 39.24", үнэмлэхүй өндөр нь 1275 м байна. Зам усалгаанд жилд 5200м³ тэрбум мод үндэсний хүрээнд 6075м³ ус хэрэглэнэ. Ил уурхайн шүүрлийн усны хэмжээ нь жилд 27063м³-ээс 31320м³ хооронд байна.

Ордыг ашиглахад шаардлагатай усыг ил уурхайн шүүрлээс хангаж хүрэлцэхүйц байна. Шавхан зайлуулах усыг тоолууржуулж бодит шавхалт болон хэрэглээнээс төлбөр төлөхийг зөвлөж байна.

Хог хаягдал

Тухайн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ноцтой хохирол учруулахуйц хатуу, шингэн хог хаягдал гарахгүй. Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдал нь ахуйн болон бусад үйл ажиллагаанаас үүснэ.

Ахуйн хог хаягдал: Ордын ахуйн гаралтай хатуу хог хаягдлын эх үүсвэр нь ажилчдын хэрэглээ юм. Хатуу хог хаягдлын дийлэнх хувийг сав баглаа боодол эзэлнэ. Төслийн үйл ажиллагаанаас доорх нэр төрлийн хатуу хог хаягдал гарна.

Уурхайн хувьд ахуйн гаралтай хатуу хог хаягдлын эх ажилчдын ажлын байран дээрх хугацаанд үүсэх хог хаягдал орно. Нэгдсэн хогийн цэг байгуулах шаардлагагүй, харин зөөврийн хогийн сав байршуулах шаардлагатай.

Ахуйн хог хаягдлыг тогтмол хугацаанд үйлдвэрийн нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн хүргэж шил, металл зэргийг хоёрдогч түүхий эдийг ангилан цааш борлуулж байх нь зүйтэй. Ажиллах хүний тоо ТЭЗҮ-ийн “Пауэрлэнд” ХХК-ийн ажилчдын орон тооны хэсгээс зөвхөн нэг ээлжинд ажиллах хүний тоогоор тооцоололоо. Иймд төслөөс гарах хатуу хог хаягдлыг нийт 50 хүнээр тооцсон болно. Нэг хүний хоногт үүсгэх хог хаягдлын хэмжээ 0.41 кг байна.

Хүснэгт 5. Ахуйн хог хаягдлын тооцоо

Ашиглалтын жил	Жилд ажиллах хугацаа, хоног	Нэг хүний хоногт үүсгэх хог хаягдал, кг	Нэг ээлжинд ажиллах хүний тоо, ш	Нэг жилд гарах хог хаягдлын хэмжээ, тн	Нийт ашиглалтын жилд гарах хог хаягдлын хэмжээ, тн
10	365	0.41	50	7.48	74.82

Дээрх хүснэгтээс Алагтолгойн уурхайд жилд ойролцоогоор 7.48 тн ахуйн хог хаягдал гарахаар байна. Тус компани нь ахуйн хог хаягдлыг Даланжаргалан сумын засаг даргатай гэрээ байгуулж, тогтмол зайлуулдаг байх шаардлагатай.

Шингэн хаягдал: Ордын шингэн хаягдлын эх үүсвэр нь ажилчдын хэрэглээ байна. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтын дагуу “Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон нийтийн байр бол 80 л/хоног/хүн”-р тооцсон болно. Үүнд:

Хүснэгт 6. Шингэн хаягдлын тооцоо

Ашиглалтын жил	Жилд ажиллах хугацаа, хоног	Ус хэрэглээний хоногийн дундаж норм, л/хоног/хүн	Нэг ээлжинд ажиллах хүний тоо, ш	Нийт, тн/жил	Шингэн хаягдал /70%/, тн/жил
10	365	80	50	1460.0	1022.0

1.5.Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

2024 онд уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу 100.0 мян.тн нүүрс олборлохоор төлөвлөсөн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газарзүйн нөхцөл

“Алагтолгойн уурхай” нь Монгол орны цөлөрхөг хээрийн бүсийн хойт хэсэгт Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг Алагтолгой, Арын худаг нэртэй газарт оршино. Улаанбаатар хотоос урагш 270 км зайд, Даланжаргалан сумын төвөөс 28 км зайд байрлана. Монгол орны физик-газарзүйн мужлалаар Монголын дорнод талын их мужийн Халхын дундад ба Дарьгангын талархаг мужийн Халхын дундад ухаа гүвээт талын тойрогт багтана. Энэ бүс нутаг жижиг гүвээлэг, толгодлог гадаргуу зонхилох бөгөөд шорвог устай жижиг нуурууд, түүний хуурай ай савууд, хужирлаг цайдам, хөндий бүхий хотгоруудын хаяа, хязгаар нь алсуур налуу, сулхан хэрчигдэлтэй оршдог онцлогтой.

Алагтолгойн уурхайн газар нь толгодлог газар бөгөөд үнэмлэхүй өндөр нь 1250-1300 м, харьцангуй өндөр нь 19 м. Чулуулгийн үндсэн илэрц нь толгодын орой хэсэг мөн бага хэмжээгээр толгодын хажуу тал, хаяа, хөндий, хуурай сайруудын ёроолд тус тус тохиолддог.

Ландшафт

Төв Азийн өндөрлөг тал, хотгор, уулт их мужийн Монголын зүүн өмнөд хэсгийн суурьт болон давхаргат өндөрлөг тал, хотгор, сэргэж хэлбэршсэн үлдмэл-цулдам уул, бэлэрхэг уулын муж, Сайншандын хотгор, суурьт болон давхаргат өндөрлөг тал, сэргэж хэлбэршсэн үлдмэл-цулдам уул, бэлэрхэг уул бүхий цөлжүү хээр, заримдаг цөлийн дэд муж, Их-Хэтийн цөлжүү хээр, хужир мараагийн бүсэд хамаарна.

Цаг уур, уур амьсгал

Эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд багтах ба хоногийн температур эрс хэлбэлздэг, хур тунадас бага, агаарын харьцангуй чийгшилт багатай, хуурайвтар байдаг. Сарын хамгийн бага дундаж температур нь нэгдүгээр сард -12° -оос -25° С, хамгийн өндөр дундаж температур нь $+20^{\circ}$ -оос $+22^{\circ}$ С байдаг. Хур тунадас бага унадаг, жилд дунджаар 160-180 мм хүрдэг. Салхины хурд зарим үед 15-18 м/сек хүрдэг.

Геологи, геоморфологи

Геологи Алагтолгойн уурхайн геологийн судалгаа нь 1940-өөд оноос бүс нутгийн хэмжээнд эхэлсэн бөгөөд тус судалгаагаар Алагтогоогийн нүүрсний илрэл анх тэмдэглэгдсэн байдаг. 1954 онд А.Н.Ефимов, З.А.Кузнецов нар Алагтогоогийн орчимд тархсан талбайг бүхэлд нь хамарсан геологийн анхны судалгааны ажлыг хийсэн бөгөөд тус судалгаанд уг талбайн геологийн тогтоц нь дунд палезой, юра, цэрд, гуравдагч,

дөрөвдөгчийн хурдсаас бүрдэнэ гэж үзжээ. 1963 онд В.В.Соловьев,.Ц.Соловьева нар Алагтогоогийн нүүрсний орд дээр хурдавчилсан хайгуулын ажлыг хийсэн байдаг. Тус ордын нүүрсийг Г-Д маркийн нүүрсэнд хамаарагдах сайн чанарын нүүрс гэж үзсэн байна. 1998-1999 онд “Монгол Алт” ХХК нь өөрийн хөрөнгөөр Алагтогоогийн нүүрсний ордод эрэл хайгуулын ажил хийж Алагтогоогийн нүүрсний орд нь Элдэв, Далан, Жаргалант, Алагтогоо гэсэн 4 хэсгээс бүрдсэнийг тогтоож Элдэвийн хэсэгт нарийвчилсан хайгуул, Далан, Жаргалантын хэсгүүдэд эрэл үнэлгээний ажил гүйцэтгэсэн байна.

Алагтолгойн уурхайн геологийн тогтоц нь дээд юрийн конгломератын давхарга, доод цэрдийн нүүрс агуулсан эх газрын бялхмал-тунамал хурдас ба дөрөвдөгчийн эх газрын тунамал хурдсаас бүрдэнэ.

Геоморфологи

Алагтолгойн уурхайн талбай нь Монгол орны геоморфологийн мужлалаар Монголын дорнод мужийн Баруун-Уртын дэд мужид хамрагдана. Тэгширмэл газар, уулс хоорондын хотос, уулан дундах хотгор дахь элэгдлийн гаралтай өргөгдмөл гадарга (Mz-Q), Ул чулуулаг дээрх элэгдлийн суурьт талын гүвээт, толгодот гадаргууд сайн ажиглагдана.

Гадаргын ус

Ус зүйн хувьд дэлхийн ус хагалбарын Төв Азийн гадагш урсацгүй ай савд, Монгол орны Умард говийн гүвээт, Халтын дундад талыг сав газарт багтана. Энэ ай сав дахь ихэнх голдирол нь түр зуурын урсацтай бөгөөд жилийн ихэнх хугацаанд хуурай байдаг. Алагтолгойн уурхайн талбайд урсгал ус байхгүй. Зуны улирлын сүүлч, намраар үргэлжилсэн ширүүн борооны дараа хөндий, хуурай сайруудаар хэмхдэс чулуулаг зөөвөрлөсөн түр зуурын булингартай үерийн ус урсдаг. Нутаг дэвсгэрийн хүрээнд худаг, шанд харьцангуй элбэг. Хүн, малын ундаанд удаан хугацаагаар хэрэглээгүй дарагдсан буюу усгүй худаг, шандууд ч нэлээд тааралдана. Гэвч эдгээрийн ихэнх нь эрдэсжилт ихтэй тул ундны болон техникийн хэрэгцээнд ашиглахад тохиромжгүй юм. Хайгуулын анги 10-15 км зайтай орших Цагаан-Усны худгаас ус авч байсан байна. Худгийн усны нөөц тогтоогдоогүй, ундарга нь 2 л/сек.

Гидрогеологи нөхцөл, газрын доорх усны нөөц, чанар, горим

Ордын нүүрс агуулагч чулуулгийн шүүрэлтийн шинж чанар, усжилтыг тодорхойлох зорилгоор гидрогеологийн 3 цооногийг өрөмдсөн байна. Гидрогеологийн судалгаагаар хийсэн шавхалт туршилтын ажлын үр дүнгээс харахад ордын хүрээнд усны тогтонги түвшин нь 12.3-25.1 м-ийн гүнд байрлах ба ерөнхийдөө хойноос урагш

гадаргуугийн үнэмлэхүй өндөр намссанаар усны түвшин дээшилдэг. Алагтолгойн хэсгийн талбайд тархсан чулуулгийн усжилт жигд биш, хэсгийн янз бүрийн хэсгүүдэд өрөмдсөн гидрогеологийн цооногуудын ундарга 0.3-2.1 л/с байх ба хэсгийн хойд хэсэгт төв, өмнөд хэсгээсээ харьцангуй илүү усжилттай гэж үзжээ. Дээрх судалгааны мэдээлэлүүдэд дүгнэлт хийхэд ордын хэмжээнд тархсан нүүрс агуулагч чулуулгийн усжилт нь гидрогеологийн шавхалтаар гүн рүүгээ буюу нүүрсний давхраасуудаас доош ихссэн байна. АТ11-01Н, АТ11-02Н цооногуудад 60 м-ийн гүнээс 0.2-0.4 л/с-ээр, АТ11-03Н цооногт 40 м-ээс эхлэн 0.15-0.25 л/с-ээр нэмэгдсэн байна.

Алагтолгойн хэсгийн хүрээнд тархсан уст бүрдлүүд нь өөрийн талбайд унах агаарын хур тунадасаар тэжээгдэж, ордын хүрээнд чулуулгийн ан цаваар дамжин хуримтлагдах ба усаа гипсометрийн доор орших бусад уст давхарга, бүрдлүүдэд алдана. Талбайн гадаргуугийн байдал нь өөр бусад уст давхарга, бүрдлүүдээс тэжээгдэл авах нөхцөлөөр хязгаарлагдмал юм. Газрын доорх усны горим нь жил бүр ихээхэн хэлбэлзэлтэй, агаарын хур тунадсын хэмжээнээс шууд хамааралтай байна. Шавхалтын ажлын төгсгөлд цооногуудаас усны шинжилгээний үр дүнгээр ордын хойд хэсэгт (цооног АТ11-01Н) газрын доорх усны эрдэсжилт нь 1.16 г/л, ерөнхий хатуулаг нь 5.64 мг-экв/л, төв, өмнөд хэсгүүдэд эрдэсжилт 2.28-2.41 г/л, хатуулаг нь 23.6-26.32 мг-экв/л байна.

Алагтолгойн хэсгийн гидрогеологийн нөхцөлөөс харахад агуулагч чулуулаг нь нүүрсний давхаргууд байрласан гүнд усжилт муутай, жигд бус тархалттай зэрэг нь ордыг ил аргаар ашиглах тааламжтай нөхцлийг бүрдүүлж байна.

Хөрсөн бүрхэвч

Хөрсний бүтэц нь өөрийн тархалт, зузаанаараа харилцан адилгүй тархалттай. Талбайн хэмжээнд хүрэн, чулуурхаг хүрэн хөрсүүд ялгагдана. Хүрэн хөрс нь голдуу элсэнцэр, шавранцар агуулах ба чулуурхаг хүрэн хөрс нь элюви-делювийн гаралтай шавар, шавранцраас тогтоно. Хөрсний үеийн зузаан нь 0.05-0.2 м хааяа 0.3-0.4 м хүртэл хэлбэлзэнэ.

Алагтолгойн уурхайн талбай нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн Хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүс, Бор Өндөр-Уулбаяны тойрогт хамаарагдана (ШУА, Газарзүйн хүрээлэн, 2009).

Төслийн талбайд уулын хүрэн хөрс, жинхэнэ хүрэн хөрс тархсан байна. Хээрийн судалгаагаар “Алагтолгой” хэсэгт 10, “Арын худаг” хэсэгт 2, нийт 12 цэгт хөрсний зүсэлт хийсэн. Ингэхдээ хөрсний агрохимийн 12 дээж, хөрсний хүнд металл 4 дээж, эрүүл ахуй 3 задлан шинжилгээ хийлгэсэн.

Шинжилгээний үр дүнгээр хөрс нь дунд зэрэг шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялмагийн агууламж дунд, цахилгаан дамжуулах чанар бага давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон хөдөлгөөнт калийн хангамжаар бага байна. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дунд байна. Хүнд металлын агууламжаар MNS5850:2019-д заасан хөрсөнд агуулагдах хүлцэх агууламжаас бага буюу хэтрээгүй байна.

Биологийн олон янз байдал

Алагтолгойн уурхайн талбай нь ургамал газарзүйн мужлалын хувьд Евроазийн хээрийн их муж Дагуур-Монголын дэд их муж Говийн умард-Дорнод хамаарна (Үндэсний атлас, 1990). Төслийн талбай орчимд 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр бэлчээрийн ургамлын судалгаа гүйцэтгэхэд нийт 3 бүлгэмдэлийн 15 овгийн 31 төрлийн 40 зүйл ургамал тэмдэглэгдсэн. Энэхүү ургамлууд нь амьдралын хэлбэрийн хувьд сөөг-2 (5%), сөөгөнцөр-1 (2%), сөөгөнцөрлөг-3 (8%), олон наст- 22 (55%), нэг ба хоёр наст-12 (30%) зүйл ургамал тус тус тэмдэглэгдсэн.

Үетэн агьт-шавагт бэлчээрийн зонхилогч зүйл нь *Artemisia frigida*-аг Шарилж, дэд зонхилогч *Artemisia caespitosa* дэгнүүлт шарилж, *Stipa krylovii*-крыловын Хялгана, *Elymus chinensis*-нангиад Түнгэ зэрэг үетэн ургамлууд бүрдүүлж байна. Үүний зэрэгцээ *Carex duriuscula*-ширэг Улалж, *Allium anisopodium*-шувуун хөл Сонгино, *Caragana stenophylla*-нарийн Харгана, *Heteroparus hispidus*-арзгар Согсоолж, *Elymus chinensis*-нангиад Түнгэ зэрэг ургамлууд зонхилон ургасан. Хялгана- хазаар алаг өвст бүлгэмдэл (*Stipa krylovii*, *Agropyron cristatum*, *Cleistogenes songorica*, *Caragana microphylla*, *Carex duriuscula*, *Caragana stenophylla*, *Potentilla bifurca*, *Artemisia pectinata*, *Artemisia macrocephala*, *Convolvulus ammannii*, *Allium mongolicum* зэрэг ургамлууд ургана. Судалгааны талбайн 80629га талбайг бүрдүүлж байна.

Дэрст бүлгэмдэл (*Achnatherum splendens*, *Agropyron cristatum*, *Elymus chinensis*, *Artemisia frigida* зэрэг ургамлууд ургана.

Алагтолгойн уурхайн байршил нь “Монгол улсын хөхтөн амьтны улаан данс”-д оруулсан мужлалын ангиллаар Дорнод говийн мужид хамрагдана. Бүс нутаг нь цөлжүү хээрийн ландшафттай тул хуурай, задгай нөхцлийг бараадан орших амьтны аймаг зонхилно. Амьтны газарзүйн мужлалаар Азийн уулархаг дэд их мужийн Монголын-Түвдийн муж, Монгол дагуурын тойрог ба говийн дэд мужийн хойд говийн тойрогт хамаарна.

Хөхтөн амьтдаас 6 багийн 23 зүйл хөхтөн амьтан тэмдэглэв. Үүнд: зараа хэлбэртэн 2, гар далавчтан 1, туулай хэлбэртэн 2, мэрэгчтэн 13, мах идэштэн 4, туруутан 1 зүйл орно. Энд хээрийн экосистемийн үндсэн гишүүд болох үнэг, хярс, чоно зэрэг

махчид, цагаан зээр байхаас гадна мөн говийн амьтны аймгийн зарим төлөөлөл илэрнэ. Эдгээрээс цагаан зээр нь улирлын байдал, бэлчээрийн гарц даган нүүдэллэх байдалтай тохиолдоно.

Энэ нутагт манай орны шувуудын 33,1 хувь буюу 156 зүйл шувуу тэмдэглэгдсэн. Эдгээрээс суурин 17, нүүдлийн (өндөглөдөг) 33, нүүдлийн өндөглөдөггүй 21, дайрч өнгөрдөг 77, ирж өвөлждөг 5, тохиолдлоор үзэгддэг 3 зүйл байдаг. Задгай ус тэг ховор учир усны шувууд бараг л тохиолдохгүй. Худаг ус, өвөлжөө, хаваржаа орчимд хадны болон хөхвөр тагтаа, хээрийн болон оронгийн бор шувуу, элээ, хотны бүгээхэй, ууль, өвөөлж, хар болон хон хэрээ, шаазгай зэрэг шувууд тохиолдно.

Эргэн тойронд 3 зүйлийн гүрвэл (монгол гүрвэл, могой гүрвэл, цоохор хонин гүрвэл), 2 зүйлийн могой (бамбай хоншоорт могой, рашааны могой) тохиолдоно. Эдгээрээс могой гүрвэл, цоохор хонин гүрвэл гэсэн хоёр зүйл нь Монголын говь, цөлд амьдардаг хамгийн өргөн тархалттай, тоо толгойн өндөр нягтшил бүхий зүйлүүд юм.

Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын өв

Алагтолгойн уурхайн талбайгаас газарзүйн хувьд хамгийн ойр байрлах тусгай хамгаалалттай газар нутаг нь Чойрын богд уулын байгалийн нөөц газар (БНГ) 21 км зайтай оршдог. Харин засаг захиргааны бүсийн хувьд хамгийн ойр байрдаг нь Их нартын байгалын цогцолборт газар байна. Төслийн талбай нь улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй. Мөн төслийн талбайд түүх, соёлын өв бүртгэгдээгүй байна.

Нийгэм, эдийн засаг

Алагтолгойн уурхай байрлах Даланжаргалан сум нь 3007 хүн амтай, 963 өрхтэй, үүнээс 448 өрх нь Элдэв багт суурьшдаг байна. Аймгийн хэмжээнд 2024 оны 2-р сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 13602.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3863.9 (39.7%) сая төгрөгөөр өссөн байна.

Энэхүү өсөлтөд тэтгэврийн даатгалын сан 1986.6 (27.8%) сая төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сан 754.6 (3.2 дахин) сая төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сан 610.9 (2.7 дахин) сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сан 384.2 (21.0%) сая төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сан 127.6 (2.8 дахин) сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Хүснэгт 7. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

№	Матрицын зураг Байгаль орчны үзүүлэлт	Нөлөөллийн чанар			Нөлөөллийн зэрэг					Нөлөөллийн үргэлжлэх хугацаа		
		Эерэг (+)	Сөрөг (-)	Нөлөөгүй (0)	1	2	3	4	5	Урт	Дунд	Богино
1. Байгаль орчны төрөл зүйлийн өөрчлөлт												
1	Гадаргын усны чанарын өөрчлөлт			x	x							x
2	Гадаргын усны нөөц хомсдох		x	x	x							x
3	Гүний усны нөөц хомсдох		x			x						x
4	Ургамлын бүтцийн өөрчлөлт		x				x					x
5	Хөрсний элэгдэл, эвдрэл		x				x					x
6	Геологийн тогтоц өөрчлөгдөх, ашигт малтмалын нөөц хомсдох		x					x		x		
7	Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт		x		x							x
8	Уур амьсгалын өөрчлөлт		x		x							x
2. Байгалийн нөөц ашиглалт												
1	Газрын гадаргын нөөц баялаг		x				x				x	
